



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2018/170/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн: “Баталгаа аудит” ХХК
Ахлах аудитор Н.Хүрэлчулуун
Аудитор Л.Батсүрэн

Улаанбаатар хот 2018 ОН

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	
2. Аудитын тайлан	
2.1. Оршил.....	1
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорил, түүний үр дүн.....	3
2.5. Дотоод хяналт.....	3
2.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7. Шилэн дансны мэдээлэл.....	4
2.8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	4
2.9. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл...	5
2.9.1. Б.Бямбаагийн төлөх өрийн талаар.....	5
2.9.2. Түрээсийн гэрээний талаар.....	5
2.9.3. Тушаал, шийдвэргүй зарцуулсан хөрөнгийн талаар.....	5
2.10. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	6
2.12. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	6
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.15. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
3. Менежментийн захидал.....	7
3.1. Түрээсийн гэрээний талаар.....	8
3.2. Тушаал, шийдвэргүй зарцуулсан хөрөнгийн талаар.....	9
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	10
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.4. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19



2018.03.15

06/736

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хөдөө аж ахуйн их сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1. Оршил

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал Т.Хэрүүга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Тус сургуулийн захирал асан Б.Бямбаагийн шүүхийн шийдвэрээр төлөх өр 468,0 сая төгрөгийг санхүүгийн тайланд 2015 оноос хойш авлагаар бүртгэж ирсэн боловч төлүүлээгүй тул тодорхой хугацаатай албан шаардлага бичив.

Түрээсийн орлогоос улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн 1.6 сая төгрөгийг төлүүлэх акт бичиж, цаашид түрээсийн гэрээ хийхгүйгээр төрийн өмчийн байрын талбайг ашиглуулахгүй байх, хөрөнгө, мөнгө зарцуулахдаа тушаал шийдвэр гаргаж байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 5-наас 2018 оны 3 дугаар сарын 4-ний хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Баталгаа аудит ХХК-ний ахлах аудитор Н.Хүрэлчулуун, аудитор Л.Батсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Хөдөө аж ахуйн их сургууль 2018 оны 01 дүгээр сарын 24-нд Баталгаа аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хөдөө аж ахуйн их сургууль нь Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д ...Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино... гэж заасны дагуу үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Сургуулийн Удирдах зөвлөлийн 2013-08-20-ны өдрийн хуралдаанаар “Хөдөө аж ахуйн их сургуулийн дүрэм”-ийг баталсан бөгөөд 1.3-т ...Их сургуулийн үндсэн зорилго нь иргэнд дээд боловсрол эзэмшүүлэх, шинжлэх ухааны суурь болон хавсрага судалгаа эрхлэн шинэ мэдлэг бүтээх, хүн амд мэдлэг түгээх, боловсрол, соёлын төвшинг нь дээшлүүлэхэд оршино..., 1.3.1-д ... ХААИС-ийн эрхэм зорилго нь хөдөөгийн хөгжлийг тэргүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, сургалтыг үйлдвэрлэл, бизнестэй хосолсон манлайлах их сургууль болоход оршино... гэжээ. 1.5-д ...Их сургууль нь үндсэн үйл ажиллагаа/сургалт, мэдлэг үйлдвэрлэл/-ны хувьд ашгийн төлөө бус байгууллага бөгөөд зардлаа нөхөх санхүү, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, суралцагч, багш, ажиллагсдын ажиллаж амьдрах орчин, нөхцөл, материаллаг хангамжийг дээшлүүлэх, мэдлэгийг үйлдвэрлэл, бизнес болгох чиглэлээр холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулна... гэжээ.

Хөдөө аж ахуйн их сургууль үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, Дээд боловсролын тухай, Хөдөлмөрийн тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Нийгмийн даатгалын тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Боловсролын тухай болон бусад холбогдох хуулиуд, УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн бүтэц, орон тоо, ажиллагсдын нэрс, албан тушаал, цалингийн зэрэглэлийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн холбогдох заалтуудыг үндэслэн захирлын 2017 оны 1 дүгээр сарын 04-ний А-01, Б/01 тоот тушаалуудаар баталсан байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Иргэнд дээд боловсрол эзэмшүүлэх, шинжлэх ухааны суурь болон хавсрага судалгаа эрхлэн шинэ мэдлэг бүтээх, хүн амд мэдлэг түгээх, боловсрол, соёлын төвшинг нь дээшлүүлэх, хөдөөгийн хөгжлийг тэргүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, сургалтыг үйлдвэрлэл, бизнестэй хосолсон манлайлах их сургууль болоход оршино... гэжээ. 1.5-д ...Их сургууль нь үндсэн үйл ажиллагаа/сургалт, мэдлэг үйлдвэрлэл/-ны хувьд ашгийн төлөө бус байгууллага бөгөөд зардлаа нөхөх санхүү, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, суралцагч, багш, ажиллагсдын

ажиллаж амьдрах орчин нөхцөл, материаллаг хангамжийг дээшлүүлэх, мэдлэгийг үйлдвэрлэл, бизнес болгох зэрэг болно.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

ХААИС-ийн алсын хараа нь “тогтвортой хөгжлийн төлөө”, эрхэм зорилго нь “азийн шилдэг их сургуулийн эгнээнд багтах”, үнэт зүйлс нь “суралцах таатай орчин, оюунлаг, бүтээлч, хариуцлагатай хамт олон, эрдэм мэдлэг, амьдрах чадвар, ёс зүйтэй оюутнууд, хөгжил дэвшилд манлайлагч байх, эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах” зэрэг болно.

Байгууллагын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга/захирал, эрхлэгч/ тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны төсвийг Сангийн яамны санхүүжилт болон суралцагсдын сургалтын төлбөр, бусад орлогоос бүрдүүлсэн байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг гол шалгуур болголоо.

Аудитаар Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 25 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/


Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хөдөө аж ахуйн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Хөдөө аж ахуйн их сургууль нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нотлох үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь



материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сургуулийн дотоод хяналтын албанд 2016 оны 04 сараас дотоод аудиторор Б.Номин ажиллаж эхэлсэн бөгөөд 2017 онд бүтэн ажилласан байна. Захирлын 2015 оны А/211 тоот тушаалаар “Дотоод аудитын журам”-ыг баталж мөрдүүлжээ. Дотоод аудитор нь сургуулийн захиргааны албаны даргын удирдлагад ажилладаг. Дотоод аудитор нь 2017 онд 2016 оны 1-12 саруудын кассын баримтуудыг шалгасан, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянасан, жилийн эцсийн тооллогын дараа тооллого хийгдээгүй Нарт төвийн үндсэн хөрөнгийн тооллогод биечлэн оролцсон, тушаал, шийдвэрүүдийн хэрэгжилтийг шалгасан зэрэг ажлуудыг хийсэн байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд сул гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

2.6. Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 онд улсын төсвөөс олгох тогтмол зардлыг сар, улирлын хуваарийн дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн сангаас тус сургуулийн Хаан банкин дахь харилцах дансанд шилжүүлжээ. Тус сургууль нь Хаан, Голомт, Төрийн, Хас, УБ, Капитрон зэрэг банкинд харилцах данс нээлгэн гүйлгээ хийсэн байна. Хөдөө аж ахуйн их сургууль нь 2017 онд улсын төсвөөс тогтмол зардалд 1,128.2 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Улсын төсвөөс авах ус, дулааны авлага өмнөх оны эцэст 719.6 сая төгрөг, тайлант оны эцэст 470.6 сая төгрөг байна. 2017 онд гэрэл, цахилгаанд 385.9 сая төгрөг, түлш халаалтанд 233.6 сая төгрөг, цэвэр, бохир усанд 264.7 сая төгрөг бүгд 884.3 сая төгрөг зарцуулжээ. ХААИС-ийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь 2017 оны эхэнд 2,748.5 сая төгрөгийн, оны эцэст 3,053.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.7. Шилэн дансны мэдээлэл

Хөдөө аж ахуйн их сургууль нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан бөгөөд 2017 онд нийтдээ 876 гүйлгээ орсон байна.

2.8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын чиглэлээр 26 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 25 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй байгуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.



2.9. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1. Б.Бямбаагийн өрийн талаар:

Дүүргийн эрүүгийн хэргийн 2 дугаар шатны шүүхийн 2015 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 180 тоот шийтгэх тогтоол, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2015 оны 3 дугаар сарын 26-ний өдрийн 236 тоот магадлалыг үндэслэн гаргасан 2015 оны 6 дугаар сарын 23-ний өдрийн 956 тоот гүйцэтгэх хуудсанд заасан 468.0 сая төгрөгийг тус сургуулийн захирал асан Бадарчийн Бямбаагаар төлүүлж тус сургуулийн дансанд оруулахаар 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 1 тоот “Төлбөр барагдуулах гэрээ”-г ХААИС-ийн Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн дэд захирал Ж.Батчулуун иргэн Б.Бямбаатай байгуулжээ. Энэ гэрээний 1.2-д зааснаар дээрхи төлбөрийг 2015 оны 10 дугаар сараас 2016 оны 4 дүгээр сарыг дуустал төлж барагдуулахаар график гаргажээ. Гэвч 468.0 сая төгрөгийг гэрээний дагуу төлүүлээгүй, сургуулийн зүгээс удаа дараа шаардлага тавьж байсан боловч хэрэгжүүлээгүй явж иржээ. Үүний улмаас 468.0 сая төгрөгийн төлбөрийг барагдуулахгүй, шүүхийн шийдвэр биелэгдэхгүйд хүрсэн байна

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д ...эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах..., Төсвийн тухай хуулийн 6.4.8-д ...төсвийг зохистой удирдаж авлага, өр, төлбөр үүсгэхгүй байх... гэсэн заалтуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгон өрийг 2018 оны 6 дугаар сарын 30-нд багтаан төлүүлэх албан шаардлага өглөө.

2.9.2. Түрээсийн гэрээний талаар.

Хөдөө аж ахуйн их сургуулийн хичээлийн төв байранд иргэн Н.Бор, М.Элик, ЭЗБС-ийн байранд иргэн Н.Сайханбаяр, МЭС-ийн байранд иргэн Г.Энхцолмон, Оюутны 2-р байранд иргэн М.Хадбаатар, Оюутны 1-р байранд иргэн О.Гиваасүрэн нарт нийт 385.8 м2 талбайг түрээсийн гэрээгүй ашиглуулж 36.0 сая төгрөгийн орлого олсон бөгөөд энэ орлогын 30%-ийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн сан дахь 100900000703 тоот дансанд дутуу төлсөн байна. Энэ нь “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 2 дахь заалт “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах” хэсгийн 12 дугаар заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 102 дугаар тогтоолын 2 дахь заалтыг биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 2 дахь хэсгийн 12-т “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журамд нийцүүлэн бичгээр байгуулна.”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 102 дугаар тогтоолын 2.Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30%-аар тогтоож... гэж заасныг мөрдөж ажиллах, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 20-ны 102 дугаар тогтоолын 2-т “Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30%-аар тогтоож, 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгон дутуу төвлөрүүлсэн 1.6 сая төгрөгийг 2018 оны 04 дүгээр сарын 10-ний дотор багтаан төвлөрүүлэх ажлыг бичив.

2.9.3. Тушаал, шийдвэргүй зарцуулсан хөрөнгийн талаар.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Хөдөө аж ахуйн их сургуульд Лаос, БНСУ-аас ирсэн төлөөлөгчдийн хүлээн авалт, мөн сургуулийн лабораторийн нээлтийн зардалд 3.8 сая төгрөгийг захирлын тушаал шийдвэргүйгээр зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 –д... анхан шатны баримт бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно... гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

2.10. АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

ХААИС-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар цаашид түрээсийн гэрээний биелэлт, гэрээ дүгнэсэн байдал, Б.Бямбаагийн өрийн асуудлыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

ХААИС-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 507.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 468.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1.6 сая төгрөгийн 1 акт, 39.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

2.13. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ХААИС-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2,110.5 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 4 зөвлөмжөөс 2 зөвлөмж биелэгдэж 2 зөвлөмж биелэгдээгүй байна.

2.14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

ХААИС-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 18,455.3 сая төгрөг бөгөөд 1.1 хувиар буюу 203.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг шинэчлэн тодорхойлж, баталгаажууллаа.

2.15. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид ХААИС-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иймд ХААИС-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь ХААИС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1.Түрээсийн гэрээний талаар**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Хөдөө аж ахуйн их сургуулийн хичээлийн хичээлийн төв байранд иргэн Н.Бор, М.Элик, ЭЗБС-ийн байранд иргэн Н.Сайханбаяр, МЭС-ийн байранд иргэн Г.Энхцолмон, Оюутны 2-р байранд иргэн М.Хадбаатар, Оюутны 1-р байранд иргэн О.Гиваасүрэн нарт нийт 385.8 м2 талбайг түрээсийн гэрээгүй ашиглуулж 36.0 сая төгрөгийн орлого бөгөөд энэ орлогын 30%-ийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн сан дахь 100900000703 тоот дансанд дутуу төлсөн байна. Энэ нь “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 2 дахь заалт “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах” хэсгийн 12 дугаар заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 102 дугаар тогтоолын 2 дахь заалтыг биелүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

“Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 12-д “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журамд нийцүүлэн бичгээр байгуулна.”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 102 дугаар тогтоолын 2-т “Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30%-аар тогтоож...” гэсэн заалтыг мөрдөж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Төрийн өмчийг түрээсээр ашиглуулах журам зөрчигдөх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.2. Тушаал шийдвэргүй зарцуулсан
хөрөнгийн талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Хөдөө аж ахуйн их сургуульд Лаос, БНСУ-аас ирсэн төлөөлөгчдийн хүлээн авалт, мөн сургуулийн лабораторын нээлтийн зардалд зарцуулсан 3.8 сая төгрөгийг захиралын тушаал шийдвэргүйгээр зарцуулсан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д...анхан шатны баримт бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайлант тусгахыг хориглоно... гэсэн заалтыг мөрдөж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтууд зөрчигдсөн

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлынтайлан**

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	2,748,494,368.55	3,053,620,640.14
Кассанд байгаа бэлэн мөнгө	856,765.50	175,444.50
Банкинд байгаа бэлэн мөнгө (төгрөгөөр)	2,747,637,603.05	3,053,445,195.64
Банкинд байгаа бэлэн мөнгө (гадаад валютаар)		
Богино хугацаат хадгаламж		
ДАНСНЫ АВЛАГА	6,436,981,749.08	5,259,213,229.34
СУРГАПТЫН ТӨЛБӨРИЙН АВЛАГА	4,612,952,182.00	3,998,032,230.78
Диплом ромбоны авлага		
Сургалтын төлбөрийн авлага	4,205,886,907.00	3,998,032,230.78
Сургалтын төрийн сангийн авлага	407,065,275.00	
ХЭРЭГЛЭГЧДИЙН АВЛАГА	719,639,859.00	470,642,000.00
Цахилгааны авлага		
Орон сууцны авлага		
Ус, дулааны авлага	719,639,859.00	470,642,000.00
АЖ АХУЙН ТООЦООНЫ АВЛАГА	1,104,389,708.08	790,538,998.56
Нарт төвийн авлага		
Хэвлэх цехийн авлага		
Иноваци төвийн авлага		
Мужаан цех, цонх хаалганы авлага		
Сургалтын бус үйл ажиллагааны авлага	462,000,000.00	468,018,348.00
Оюутны байрны авлага		
Түрээсийн авлага		
Бусад авлага	369,883,566.08	310,616,385.36
ШУТ Сангийн авлага		
Дотоод тооцоо-Санхүүжилт		
Төсөл хөтөлбөрийн тооцоо	272,506,142.00	11,904,265.20
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	518,395,018.02	523,117,723.89
БМ, ҮХ бэлтгэх урьдчилгаа	111,389,418.85	123,804,764.72
